



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/79

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв, Сэлэнгэ аймгийн зарим сумдад оторлож байгаа 218 малчин өрх тус бүрт түлээ нүүрсний үнийн дэмжлэг үзүүлэх 35,000 (гучин таван мянга) төгрөг, Төв аймгийн Баянхангай, Баянцогт, Жаргалант, Заамар сумдад тус бүр 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг, Төв аймгийн Цээл, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумдад тус бүр 3,000,000 (гурван сая) төгрөг, Дорноговь аймгийн Иххэт суманд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг, Алтан ширээ суманд 5,000,000 (таван сая) төгрөгийг тус аймгаас оторлож буй малчдад төрийн үйлчилгээ үзүүлэх зардалд, Өмнөговь аймаг дахь өвс, тэжээлийн Улсын нөөцийн цэгээс 2500 боодол өвсний ачаа тээвэр, ачилтын зардал 9,950,000 (есөн сая есөн зуун тавин мянга) төгрөг, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд тус аймгийн Бат-Өлзий, Баянгол, Төгрөг, Гучин-Ус сумдад хүргэсэн хүчит тэжээлийн тээврийн зардалд 7,225,000 (долоон сая хоёр зуун хорин таван мянга) төгрөг, Аймгийн өвс, тэжээлийн нөөцөд байгаа задарсан өвсийг савлах шуудайны үнэ 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 40,905,000 (дөчин сая есөн зуун таван мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Дээрх аймгуудад оторлож байгаа малчин өрхийн судалгааг гаргаж, малчдын дансанд шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100174

Аймгийн Засаг даргын 2021 оны...
 дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр
 захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Арга хэмжээний нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/	Тайлбар
1.	Төв, Сэлэнгэ аймгийн зарим сумдад оторлож байгаа 218 малчин өрхөд түлээ нүүрсний тусламж	218	35,000	7,630,0	Түлээ нүүрсний дэмжлэг аваагүй Төв аймгийн 15 сум, Сэлэнгэ аймгийн 10 сумд
2.	Төв аймгийн Баянхангай, Баянцогт, Жаргалант, Заамар, Цээл, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Дорноговь аймгийн Иххэт, Алтан ширээ сумдад тус аймгаас оторлож буй малчдад төрийн үйлчилгээ үзүүлэх зардалд			18,500,0	
3.	Өмнөговь аймаг дахь өвс, тэжээлийн Улсын нөөцийн цэгээс	2500	3600	9,000,0	
4.	Өмнөговь аймаг дахь өвс, тэжээлийн Улсын нөөцийн цэгээс	2500	380	950,0	Нэг боодол өвсийг нөөцийн цэгээс 380 төгрөгөөр ачиж өгсөн
5.	Баянгол, Төгрөг, Гучин-Ус сумдад хүргэсэн хүчит тэжээлийн тээврийн зардалд	253 тонн	25,000	6325,0	
6.	Бат-Өлзий суманд хүргэсэн хүчит тэжээлийн тээврийн зардалд	30 тонн	30,000	900,0	
7.	Аймгийн өвс, тэжээлийн нөөцөд байгаа задарсан өвсийг савлах шуудайны үнэ	500	1200	600,0	
	Нийт			43,905,0	